



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/004/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Даланзадгад хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Чойдорж Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
3.1 Албан шаардлага.....	10
3.2 Зөвлөмж .....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	13
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.08.25 № 344

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ  
СУМЫН ЗАСАГ

ДАРГА Б.БАТСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Сэврэй сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөтөлбөрийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн, хөтөлбөрийн хамрах хүрээнд багтаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар хөрөнгө зарцуулсан, үзүүлсэн ажил үйлчилгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй шууд гэрээ байгуулсан зэрэг 332.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар букуу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16, 4.1.17, 6 дугаар зүйлийн 6.4.2, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, 37.1.18, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050537  
F:\2.Бичиг хэрэг\2026\ИСТА\1.дүгнэлт\1.сбг1.docx

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5/02 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг 452.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 521.7 сая төгрөг бүрдүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 10 хөтөлбөр хэрэгжүүлэхээр 465.5 сая төгрөгийн төсөв батлуулж, гүйцэтгэлээр 394.9 сая төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06/03 дугаар тогтоолоор сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 94.4 хувьтай дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,221,516.9	2,931,176.7
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,411,619.5	1,515,282.1
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	137,904.6	99,952
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	3,395.7	4,968.5
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	543,303.9	1,222,285.3
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	125,293.2	88,688.8
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		140,266,922	143,627,149
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	140,266,922	143,627,149
9	1.2.2.02 Биет хөрөнгө		140,052,859.2	143,413,977.5
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	214,062.8	213,171.5
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		142,488,438.8	146,558,325.7
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,888,947.1	6,759,339.3
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		569,099.7	487,763.7
14	2.1.1.03 Өглөг		569,099.7	487,763.7
15	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,319,847.4	6,271,575.6
16	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	5,319,847.4	6,271,575.6
17	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		136,599,491.7	139,798,986.4
18	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		136,599,491.7	139,798,986.4
19	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		2,153,813	2,153,813
20	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		134,185,005.4	137,384,500
21	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		260,673.4	260,673.4
22	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		142,488,438.8	146,558,325.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		84,636,380.2	15,872,015.8
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		628,945.3	494,993.7
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		558,572.5	445,011.1
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		628,572.5	559,843.2
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-70,000	-114,832.1
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		41,037.2	14,616.9
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		29,335.6	35,365.7
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	73,142,642.5	15,377,022.1
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	6,983,612.9
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		10,864,792.3	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	14,295,926.5	8,298,426.6

12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		14,295,926.5	8,298,426.6
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,315,573.5	7,328,448.1
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,053,033.6	1,324,314.5
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		131,019.8	158,819.5
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		520,402.4	576,792.7
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		106,293.5	147,415.5
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал		6,511	4,605
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		129,525.8	144,439.9
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		15,760.4	11,310
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		445,133.3	548,629.7
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		10,907,893.8	4,412,121.4
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		980,353	969,978.5
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		70,340,453.7	7,573,589.2
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		224,432.5	4,554,752.2
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-224,432.5	-4,554,752.2
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		70,116,021.2	3,018,836.9

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	66,469,784.5		66,469,784.5
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,686.1		13,686.1
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,483,470.6		66,483,470.6
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	70,116,021.2		70,116,021.2
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,599,491.7		136,599,491.7
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	136,599,491.7		136,599,491.7
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	180,657.8		180,657.8
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,780,149.5		136,780,149.5
9	1.7 Тайлант үеийн үр дүн	3,018,836.9		3,018,836.9
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	139,798,986.4		139,798,986.4

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	12,855,700.3	9,699,064.4
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	628,945.3	494,993.7
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	558,572.5	445,011.1
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-70,000	-114,832.1
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	41,037.2	14,616.9
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	29,335.6	35,365.7
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,759.3	14,440.5
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	14,076.3	17,001.7
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,500	3,923.5
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,361,962.7	9,204,070.6
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,361,962.7	1,260,334.8
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	6,983,612.9
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	960,123
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,864,792.3	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,855,878.4	4,725,034.5
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	11,855,878.4	4,725,034.5
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,875,525.4	3,755,676.1
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,192,796.9	1,461,003.6
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,995.4	252,985.8
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	558,576.8	617,682.8
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	218,873.4	373,520.8
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	7,334	2,585
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	139,599.2	85,721.5
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	15,760.4	11,310
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	519,399.4	693,244.3
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	8,023,190	257,622.4
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	980,353	969,358.4
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	999,821.9	4,974,029.8
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	841,502.4	4,870,367.2
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	841,502.4	4,870,367.2
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	841,502.4	4,870,367.2
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-841,502.4	-4,870,367.2
33	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	158,319.5	103,662.6
34	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,253,300	1,411,619.5
35	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,411,619.5	1,515,282.1

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,157,508.6	4,064,086.7
2	3.1.01.1.1 Татварын орлого	431,787.9	494,993.7
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	388,067.9	445,011.1
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	502,900	559,843.2
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	300,000	394,789.9
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	40,000	35,583.1
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	82,900	56,741.7
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,000	170
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	79,000	72,558.6
10	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-114,832.1	-114,832.1
11	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-114,832.1	-114,832.1
12	3.1.01.1.1.1.3 Хөрөнгийн албан татвар	14,840	14,616.9
13	3.1.01.1.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,000	1,691.9
14	3.1.01.1.1.1.3.2 Бууны албан татвар	4,100	3,810
15	3.1.01.1.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	8,740	9,115
16	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	28,880	35,365.7
17	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,880	14,440.5
18	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	3,500	6,404.6
19	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500	705
20	3.1.01.1.1.8.1.07 Ус бохирдуулсны төлбөр	3,880	0.0
21	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,000	7,330.9
22	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	14,000	17,001.7
23	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	14,000	17,001.7
24	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	3,923.5
25	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	3,923.5
26	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,725,720.7	3,569,093
27	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	51,075	73,512.6
28	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	21,075	2,490
29	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	30,000	46,735.8
30	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0.0	24,286.8
31	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,714,542.7	2,535,457.4
32	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	2,714,542.7	2,535,457.4
33	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	960,103	960,123
34	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	960,103	960,123
35	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,991,728.6	4,089,254.1
36	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	4,418,927.5	3,549,762.8
37	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,378,292.9	2,586,874.8
38	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,237,760.6	1,029,300
39	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	504,759.6	452,734.4
40	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	576,275	467,529.2
41	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	55,872	34,125
42	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	69,963	44,825.8
43	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	30,891	30,085.6
44	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,522.3	145,650.3
45	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	106,475.1	101,047
46	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	12,761.7	11,377.7
47	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	6,380.9	5,415.3

48	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	6,380.9	5,092.2
49	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	25,523.7	22,718.2
50	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	761,356.9	576,792.7
51	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	62,265	46,687.3
52	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	661,820.9	500,020.4
53	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	37,271	30,085
54	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	152,537.6	129,541.3
55	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	13,156	7,984.5
56	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	51,891	41,561
57	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,964.3	4,216.6
58	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,134	70,134
59	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,392.3	5,645.2
60	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	800	0.0
61	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	800	0.0
62	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	106,913.7	88,721.5
63	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	22,000	11,273.4
64	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	84,913.7	77,448.1
65	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	16,500	6,430
66	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	16,500	6,430
67	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	615,730	538,804.8
68	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,730	538,804.8
69	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	329,171.8	71,634.3
70	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	289,171.8	61,850
71	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,000	9,784.3
72	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,040,634.6	962,888
73	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,008,543.4	944,547.5
74	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,008,543.4	944,547.5
75	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	32,091.2	18,340.4
76	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,391.2	15,140.4
77	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,700	3,200
78	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	572,801.1	539,491.3
79	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	572,801.1	539,491.3
80	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-834,220	-25,167.3
81	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	834,220	25,167.3
82	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	834,220	25,167.3
83	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	834,219.9
84	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	809,052.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,448,155.5
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,448,155.5
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	4,448,155.5
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	4,448,155.5
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	4,448,155.5
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,424,567.1
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,572.3
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,016.1
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,447,295.1
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	157,375.1
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,765.1
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,791.5

210104	1.1.1.2.1.1.4 Урамшуулал	109,791.5
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,169.2
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	7,465.8
210202	1.1.1.2.1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	1,277.7
210203	1.1.1.2.1.1.2.3 ҮОМШӨ-ний даатгал	670.1
210204	1.1.1.2.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал	579.1
210205	1.1.1.2.1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	3,176.5
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	2,566.7
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	2,566.7
2105	1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	2,585.0
210502	1.1.1.2.1.1.5.2 Хоол, хүнс	2,585.0
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	2,290.0
210702	1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт	2,290.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,362.7
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,362.7
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,610.0
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	5,610.0
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,610.0
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,289,919.9
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	4,289,919.9
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	4,289,919.9
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	860.4
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 860.4
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 860.4

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийн зардлаас "Летс трэвел" ХХК-тай шууд гэрээ байгуулан 90.0 сая төгрөг, Сайн багш-Оюунлаг сурагч дэд хөтөлбөрийн зардлаас иргэн Б.Энхтуултай шууд гэрээ байгуулан "Лаос-Тайланд-Вьетнам" улсад сургалтад хамрагдах үйл ажиллагаанд 21.0 сая төгрөг тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.1-т "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна", 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 2:** Хөтөлбөрийн зардлаас 6 төрийн албан хаагчийн дансанд 10 удаагийн нийт 76.3 сая төгрөг, "Говийн төгөлдөр чонж" хоршоонд 15.0 сая төгрөг тус тус шилжүүлсэн нь гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ үзүүлсэн нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т "хуульд нийцээгүй шийдвэр гаргах", 37 дугаар зүйлийн 37.1.18-д "хууль тогтоомжид заасан бусад үүрэг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-д

“Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгээл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 3:** Хөтөлбөрийн зардлаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 99.5 сая төгрөгийн 13 гүйлгээг төрийн албан хаагч болон иргэдийн данс руу шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгээл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 4:** Сайн төрийн албан хаагч дэд хөтөлбөрөөс олон улсын соёл солилцооны хөтөлбөрт хамрагдаж байгаа 2 оюутанд нийт 10.0 сая төгрөгийн дэмжлэг, баруун бүсийн ахмадын урлаг, спортын наадам зохион байгуулахад 7.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сэврэй сумын ИТХ-ын 2025 оны 3/11 дугаар тогтоолоор батлагдсан “Сайн төрийн албан хаагч” дэд хөтөлбөрийн 3-т “Энэхүү хөтөлбөрт тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, харьяалал бүхий босоо удирдлагатай албан хаагчид, төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын албан хаагчид...”, 3/18 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сургаал алтнаас үнэтэй” дэд хөтөлбөрийн 3-т “Энэхүү хөтөлбөрт тус сумын нийт ахмадууд хамрагдана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 5:** Ахмадын сургаал алтнаас үнэтэй дэд хөтөлбөрөөс 14.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ”, 4.1.17-д “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 6:** Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, ажиллаагүй, үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөөгүй, хууль тогтоомжид заасан албан үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 54 дүгээр зүйлийн 54.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Илрүүлэлт 1:** Нөөц сангаас Засаг даргын зөвлөлийн 15 удаагийн хурлын тэмдэглэлийг хуралдаанд оролцогчид гарын үсэг зурж баталгаажуулаагүй байхад 50.2 сая төгрөг зарцуулах захирамж гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг

дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 5.2-т "Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл баталгаажуулсны үндсэн дээр захирамж гаргах, дотоод хяналтыг сайжруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



